



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2018 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 05

Арвайхээр

Төсвийн орлого нэмэгдүүлэх, татвар хураалтыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн зам ашигласны хураамж болон бусад орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1. "е" дэх заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

1. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн зам ашигласны хураамж, бусад орлого болон албан татварын хууль, хувь хэмжээг иргэдэд сурталчилах ажлыг зохион байгуулан, татварын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, татвар хураалтын ажлыг эрчимжүүлэхийг Татварын хэлтэс (Н.Эрдэнэсүвд)-т,

2. Аймгийн тодорхой цэгүүдэд хамтарсан ажлын хэсэг гаргаж, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн зам ашигласны хураамж, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийн торгуулийн орлогоо хуулийн хугацаанд төлөөгүй иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг газар дээр нь арилгаж, орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Татварын хэлтэс (Н.Эрдэнэсүвд) нарт,

3. Албан даалгаврын дагуу арга хэмжээ авч, төсөвт төвлөрсөн орлогын дүн мэдээг 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Татварын хэлтэс (Н.Эрдэнэсүвд), аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011200010